



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/178

Улаанбаатар хот

Журмын хэрэгжилтийг хангах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь хэсэг, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.5 дахь хэсэг, "МУИС-ийн удирдах болон гүйцэтгэх ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлэх журам"-ын 10.1, 10.3 дахь хэсэг, МУИС-ийн Ректорын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/260 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "МУИС-ийн удирдах болон гүйцэтгэх ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлэх журам"-ын хэрэгжилтийн туршилтын хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан МУИС-ийн Ректорын 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/260 дугаар тушаалын 3 дахь заалтыг хүчингүй болгосугай.

2. "МУИС-ийн удирдах болон гүйцэтгэх ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлэх журам"-ын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг проректор, бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал, нэгжийн удирдлагад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан МУИС-ийн Захирал (ректор)-ын 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/376 дугаар тушаалаар батлагдсан "МУИС-ийн багш, ажилтанд мөнгөн урамшуулал олгох журам"-ыг хүчингүй болгосонд тооцсугай.

4. Удирдах болон гүйцэтгэх ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг нэгтгэж Ректорын зөвлөлд танилцуулахыг Захиргаа, хүний нөөцийн газрын дарга (С.Должин), энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөмж өгч ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга (П.Лхамсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

РЕКТОР



Б.ОЧИРХУЯГ